



МОНГОЛ УЛСЫН
БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙДЫН
ТУШААЛ

2021 оны 06 сарын 26 өдөр

Дугаар А/39

Улаанбаатар хот

Цугларалт зохион байгуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын батлан хамгаалах тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3.9 дэх заалт, Дайчилгааны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.2 дахь заалт, Орон нутгийн хамгаалалтын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэг, Засгийн газрын 2004 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан "Аймаг, нийслэл, дүүргийн цэргийн штабын дүрэм"-ийн 6 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Батлан хамгаалах яамны 2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу аймаг, нийслэл /дүүрэг/-ийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын дарга нарын "Батлан хамгаалах зорилтыг хэрэгжүүлэхэд орон нутаг дахь манлайлал" сэдэвт цугларалтыг 2021 оны 03 дугаар сарын 03-ны өдөр Батлан хамгаалах яам, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын сургалтын материаллаг баазыг түшиглэн цахим хэлбэрээр зохион байгуулж явуулсугай.

2. Цугларалтыг зохион байгуулах удирдлага, дэмжлэгийн бүрэлдэхүүн болон оролцох бүрэлдэхүүнийг нэгдүгээр, хөтөлбөрийг хоёрдугаар, шаардагдах зардлын тооцоог гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Яамны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газар /хурандаа С.Ганбямба/-т даалгах нь:

а. цугларалтын бэлтгэлийг хангаж, цугларалтын үйл ажиллагааг удирдлагаар тасралтгүй ханган, төрийн болон албаны нууцыг чанд сахиулж, сахилга, зохион байгуулалтын өндөр түвшинд явуулах;

б. цугларалтад оролцох бүрэлдэхүүний бэлтгэлийг хангуулан, цугларалтад зохион байгуулалттай хамруулах;

в. Батлан хамгаалахын сайдын 2016 оны А/88 дугаар тушаалаар батлагдсан "Аймаг, нийслэл /дүүрэг/-ийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабыг шалгаж, үнэлэх журам"-ын дагуу 2020 онд ажил үйлсээрээ манлайлсан тэргүүний цэргийн штабуудыг шалгаруулах, цэргийн штабын дарга нарт яамны 2021 оны зорилго, зорилтыг танилцуулж, үүрэг даалгавраар хангахыг;

г. цугларалтад оролцох бүрэлдэхүүнээр халдвар хамгааллын дэглэмийг сайтар сахиулахыг.


4. Цугларалтад шаардагдах 8,142,000.00 (найман сая нэг зуун дөчин хоёр

132119083

мянга) төгрөгийн зардлыг хичээл, үйлдвэрлэлийн дадлага, сургуулилтын зардлаас гаргахыг яамны Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтэс /хурандаа Д.Ганбат/-т зөвшөөрсүгэй.

5. Цугларалтыг батлагдсан хөтөлбөрийн дагуу зохион байгуулж, дүнг илтгэхийг яамны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газар /хурандаа С.Ганбямба/-т үүрэг болгосугай.

6. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /хурандаа Б.Эрхэмбаяр/-т даалгасугай.

САЙД  Г.САЙХАНБАЯР

